



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

“Дэлүүн бүргэд хайрхан” хоршооны хадгаламж,
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дэлүүн бүргэд хайрхан” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2011 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

2. Хоршооны хадгаламж, зээлийн үлдэгдэл, төлбөр тооцоог барагдуулахыг “Дэлүүн бүргэд хайрхан” хоршоо /М.Аманкелди/-нд үүрэг болгосугай.

3. Тус хоршоотой холбоотой этгээдүүдийг шаардлагатай мэдээллээр хангаж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН